

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	6
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
ГХХБГ	Газрын харилцаа, хот байгуулалтын газар
СЭЗХ	Санхүү эдийн засгийн хэлтэс
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНХҮҮ ТАНАА

2020.03.25 № 01/941
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч тус газрын дарга Ц.Ганхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлогыг аккруэл сууриар үнэн, зөв бүртгэх, санхүүгийн тайлагналыг холбогдох хууль, журам зааварт нийцүүлэх, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 5-аас 2020 оны 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Б.Энхжин хариуцан гүйцэтгэв.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 01/620 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг

гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь зорилгоо “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, технологийн, орон зайн мэдээллийн менежментийн талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх” гэж тодорхойлжээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 53,865.6 сая төгрөгийн 1 хувь буюу 538.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллага нэгтгэгдсэнээс 23 байгууллага аудитад хамрагдсан байна. Үүнээс 3 байгууллагад итгэл үзүүлж, 1 байгууллага түүвэрт хамрагдаж, 19 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт өгсөн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 19 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,305.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,130.7 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 8.3 сая төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,003.3 сая төгрөгийн 21 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 162.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 30 зөвлөмжийг хүргүүллээ.

Төвлөрүүлсэн захирагчид 108.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмжийг өгч менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 1,130.7 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Говь-сүмбэр аймгийн газрын харилцаа, хот байгуулалтын газар 2.5 сая, Өмнөговь аймгийн газрын харилцаа, хот байгуулалтын газар 40.5 сая, Сэлэнгэ аймгийн газрын харилцаа, хот байгуулалтын газар 3.2 сая, Төв аймгийн газрын харилцаа, хот байгуулалтын газар 0.6 сая төгрөгийн санхүүгийн тайлагнал, өр төлбөр, орлого, зардалтай холбоотой алдаа зөрчлийг аудитын явцад залруулсан байна.
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын санхүүгийн тайланд төлбөртэй үйлчилгээний авлага, техник хяналтын зардалтай холбоотой нийт 1,083.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулсан болно.

2.9 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 247.1 сая төгрөг болж, 169.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	20.5	35.3	14.8
Банканд байгаа бэлэн мөнгө	57.4	211.8	154.4
Дүн	77.9	247.1	169.2

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 85.7 хувь буюу 154.4 сая төгрөгийг банканд байгаа бэлэн мөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэхээр 258.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 108.2 сая төгрөгийг зарцуулахдаа тайлант үеийн орлого зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй;

- Дорнод аймгийн газрын харилцаа, хот байгуулалтын газар 55.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй;
- Орон нутгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газруудад анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин тэгэлдөр бус баримтаар нийт 513.0 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчил илэрсэн байна. Тухайлбал:
 - Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба 488.5 сая
 - Орхон аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 9.0 сая
 - Булган аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 7.5 сая
 - Бусад аймгуудын газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 8.0 сая төгрөг байна.

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 27.4 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,022.6 сая төгрөг болж, 995.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.9	16.2		12.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	4.5	985.7		981.2
Татаас, санхүүжилтийн авлага	1.2	1.2		0.0
Байгууллагаас авах авлага	12.4	7.7		-4.7
Хувь хүмүүсээс авах авлага	5.4	11.8		6.4
Дүн	27.4	1,022.6		995.2

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийн 96.4 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага эзэлж байна. Мөн ажиллагчидтай холбогдсон авлага 16.2 сая, татаас санхүүжилтийн авлага 1.2 сая байгууллагаас авах 7.7 сая, хувь хүмүүсээс авах 11.8 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Төлбөртэй үйлчилгээний авлагын 924.0 сая төгрөг буюу 93.7 хувь нь “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай техник хяналт хэрэгжүүлэх гэрээний дагуу хийгдэж буй үйлчилгээний авлага байна.

2.9.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 363.7 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 34.4 сая төгрөг болж, 329.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Урьдчилж гарсан зардал	363.7	34.4		-329.3
Дүн	363.7	34.4		-329.3

Эх сурвалж: : ГЗБГЗЗГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны техник хяналтын урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл 329.3 сая төгрөгийн тооцоог барагдуулсан нь урьдчилгаа дансны үлдэгдэл буурхад нөлөөлсөн байна.

2.9.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,238.5 сая, эцсийн үлдэгдэл 1,516.5 сая төгрөг болж, 278.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Тусгай зориулалт	111.3	104.2		-7.1

Бэлэн бүтээгдэхүүн	22.3	39.8	17.5
Бичиг хэргийн материал	257.1	311.5	54.4
Аж ахуйн материал	300.1	365.4	65.3
Сэлбэг хэрэгсэл	39.9	30.8	-9.1
Түлш, шатах тос	11.7	13.4	1.7
Барилгын засварын материал	0.7	0.0	-0.7
Бусад хангамжийн материал	482.9	637.9	155.0
Мал амьтад	12.5	13.5	1.0
Дүн	1,238.5	1,516.5	278.0

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал өмнөх оноос өссөн шалтгаан нь бусад хангамжийн материал 155.0 сая, аж ахуйн материал 65.3 сая, бичиг хэргийн материал 54.4 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,764.4 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 404.1 сая, хандив тусламжаар 4.1 сая нийт 2,172.6 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 1,894.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Булган аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар тээвэр шатахууны зардлаас 2.1 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн.

2.9.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 14,860.5 сая, эцсийн үлдэгдэл 14,902.6 сая төгрөг болж, 42.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	6,418.7	7,560.6	1,141.9
Тээврийн хэрэгсэл	579.5	723.8	144.4
Машин тоног төхөөрөмж	2,847.6	3,483.9	636.4
Тавилга эд хогшил	565.1	629.7	64.6
Зам, гүүрийн байгууламж	44.1	38.5	-5.6
Бусад хөрөнгө	112.5	104.3	-8.2
Программ хангамж	346.1	153.0	-193.1
Бусад биет бус хөрөнгө	3,946.9	2,208.8	-1,738.1
Дүн	14,860.5	14,902.6	42.1

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,050.8 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 51.3 сая, үнэ төлбөргүй болон хандив тусламжаар 2,569.6 сая нийт 3,671.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 229.5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн, 678.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж нийт 904.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлээс хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Завхан аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 0.2 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй,
- Ховд аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар эд хөрөнгийн тооллогоор 0.7 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан,
- Сэлэнгэ аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар урсгал зардлаас 3.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зөрчил илэрсэн байна.

2.9.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 222.2 сая төгрөг болж, 177.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Ажилчидтай холбогдсон өглөг	2.0	4.6		2.6
Байгууллагад өгөх өглөг	3.2	0.1		-3.1
Хувь хүмүүст өгөх өглөг	2.9	2.4		-0.5
НДШ-ийн өр /ТӨҮГ/	0.1	0.0		-0.1
Бусад өглөг	38.2	0.0		-38.2
Урьдчилж олсон орлого	353.5	215.1		-138.4
Дүн	399.9	222.2		-177.7

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 16,167.9 сая, эцсийн үлдэгдэл 17,501.1 сая төгрөг болж, 1,333.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт/+, бууралт /-/	
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,723.7	8,723.7		0.0
Өмнөх үеийн үр дүн	6,502.6	6,532.3		29.7
Тайлант үеийн үр дүн	-	1,333.2		1,333.2
Хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	941.6	911.9		-29.7
Дүн	16,167.9	17,501.1		1,333.2

Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 1,850.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 2,494.4 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 644.2 сая төгрөг буюу 34.8 хувиар давуулан биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	
Архангай аймгийн ГХХБГ	47.5	33.1	-	14.4
Баян-Өлгийн аймгийн ГХХБГ	46.5	132.9		86.4
Баянхонгор аймгийн ГХХБГ	59.2	59.4		0.2
Булган аймгийн ГХХБГ	56.5	88.2		31.7
Говь-Алтай аймгийн ГХХБГ	54.2	58.8		4.6
Говьсүмбэр аймгийн ГХХБГ	31.5	34.3		2.8
Дархан-Уул аймгийн ГХХБГ	50.0	82.8		32.8
Дорноговь аймгийн ГХХБГ	47.1	82.5		35.4
Дорнод аймгийн ГХХБГ	52.5	115.6		63.1
Дундговь аймгийн ГХХБГ	56.5	57.5		1.0
Завхан аймгийн ГХХБГ	51.5	55.0		3.5
Орхон аймгийн ГХХБГ	58.0	146.8		88.8
Өвөрхангай аймгийн ГХХБГ	56.5	60.1		3.6
Өмнөговь аймгийн ГХХБГ	57.5	114.7		57.2
Сүхбаатар аймгийн ГХХБГ	51.5	52.5		1.0
Сэлэнгэ аймгийн ГХХБГ	41.5	58.0		16.5

Төв аймгийн ГХХБГ	60.5	39.2	- 21.3
Увс аймгийн ГХХБГ	57.9	77.0	19.1
Ховд аймгийн ГХХБГ	46.8	81.3	34.5
Хөвсгөл аймгийн ГХХБГ	56.5	60.0	3.5
Хэнтий аймгийн ГХХБГ	53.5	62.8	9.3
Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	638.5	771.6	133.1
ГЗБГЗЗГ	118.5	170.2	51.7
Нийт	1,850.2	2,494.3	644.1

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 15,753.9 сая төгрөгийн урсгал зардлын төсөв батлагджээ.

Нийт зардлын 3,079.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 11,923.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 751.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,078.0 сая, тусгай зориулалтын шилжүүлэг 11,879.4 сая, орон нутгийн төсвөөс 698.9 сая төгрөг, нийт 15655.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 0.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 15,656.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсөв:

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 127.1 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгөөс 262.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,379.8 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,582.3 сая төгрөг, төсвийн урамшуулал 4.5 сая төгрөг нийт 5,356.4 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

Үүнээс 5,247.0 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 13.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэхээр 258.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 108.2 сая төгрөгийг зарцуулахдаа тайлант үеийн орлого зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслээгүй байх, тайлант үеийн үр дүн буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Орлогыг аккруэл сууриар үнэн зөв бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтуудыг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

ГЗБГЗЗГ нь өөрийн харьяа 21 аймаг, нийслэлийн санхүүгийн тайланг нэгтгэж Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж тайлагнадаг боловч Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймаг орон нутгийн газрын харилцаа, хот байгуулалтын газрын санхүүгийн тайланг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаар нэгтгэж БХБС-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд устгах бичилтийг хийж тайлагнаж байна.

Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор ГЗБГЗЗГ-ыг Төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тогтоосон боловч дээрх тогтоол нь Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх”, 61.1.5-д “Газрын харилцаа, кадастр” гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилдөж байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийн шаардлагыг хангаагүй байх, Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуурыг хангаагүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор ГЗБГЗЗГ-ыг Төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тогтоосон боловч дээрх тогтоол нь Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх”, 61.1.5-д “Газрын харилцаа, кадастр” гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгаа учир холбогдох дээд шатны байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

ГЗБГЗЗГ-ын харьяа аймаг, нийслэлийн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,305.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,130.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 8.3 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 1,003.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлага өгч, 162.8 сая төгрөгийн 30 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Дотоод хяналт сул байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,707,405.1	2,820,710.3
Мөнгөн хөрөнгө	77,861.7	247,088.9
Авлага	27,370.6	1,022,653.6
Урьдчилгаа	363,672.1	34,442.7
Бараа материал	1,238,500.6	1,516,525.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,860,473.4	14,902,608.0
Үндсэн хөрөнгө	14,860,473.4	14,902,608.0
Биет хөрөнгө	10,567,410.6	12,540,871.6
Биет бус хөрөнгө	4,293,062.8	2,361,736.3
Нийт хөрөнгийн дүн	16,567,878.5	17,723,318.3
Нийт өр төлбөр	399,962.8	222,245.1
Богино хугацаат өр төлбөр	399,962.8	222,245.1
Өглөг	8,286.8	7,104.4
Урьдчилж орсон орлого	391,686.0	215,140.7
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,167,915.6	17,501,073.2
Засгийн газрын хувь оролцоо	9,665,336.6	9,635,663.9
Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,723,751.3	8,723,751.3
Өмч /төрийн/	8,723,751.3	8,723,751.3
Хуримтлагдсан үр дүн	6,502,579.0	7,865,409.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	941,585.3	911,912.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,567,878.5	17,723,318.3

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны орлогын дүн	66,285,685.8	55,232,901.4
Татварын орлого	0.0	0.0
Татварын бус орлого	4,687,844.2	7,504,816.3
Нийтлэг татварын бус орлого	4,687,844.2	7,504,816.3
Тусламж, санхүүжилтийн орлого	61,597,841.6	47,728,085.0
Үйл ажиллагааны зардлын дүн	69,135,315.2	53,865,575.5
Урсгал зардал	69,135,315.2	53,865,575.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	63,842,355.1	48,668,476.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,924,124.4	10,628,833.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,093,467.7	1,339,354.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	443,280.9	731,540.4
Хангамж, бараа материалын зардал	1,088,316.5	1,091,903.9
Нормативт зардал	9,784.41	6,596.1
Эд хогшил, урсгал засварын зардал	148,353.2	268,106.0
Томилолт, зочны зардал	145,895.7	239,614.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,834,301.9	29,618,553.3
Бараа үйлчилгээний бусад зардал	5,154,830.3	4,743,974.1
Хүү	0.0	0.0
Татаас	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	5,292,960.2	5,197,098.8
Хөрөнгийн зардал	0.0	0.0
Үйл ажиллагааны үр дүн	-2,849,629.5	1,367,325.9
Үйл ажиллагааны бус орлогын дүн	120.7	0.0
Үйл ажиллагааны бус зардлын дүн	819,940.8	34,168.3
Үйл ажиллагааны нийт үр дүн	-3,669,570.2	1,333,157.6

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	65,695,205.2	52,547,694.2
Татварын орлого	0.0	00.0
Татварын бус орлого	3,451,080.0	4,185,125.9
Нийтлэг татварын бус орлого	3,451,080.0	4,185,125.9
Тусламж, санхүүжилтийн орлого	62,244,125.2	48,363,568.3
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	65,579,692.2	51,328,626.9
Урсгал зардал	65,579,692.2	51,328,626.9
Бараа, ажил үйлчилгээний зардал	60,179,899.2	45,825,285.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,967,865.9	10,723,933.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,067,226.5	1,306,209.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	483,515.3	644,740.4
Хангамж, бараа материалын зардал	464,461.5	567,880.5
Нормативт зардал	16,373.0	38,691.2
Эд хогшил, урсгал засварын зардал	157,754.1	284,942.8
Томилолт, зочны зардал	301,784.3	267,989.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,885,546.4	30,652,656.5
Бараа үйлчилгээний бусад зардал	835,372.3	1,337,241.2
Хүү	0.0	0.0
Татаас	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	5,399,792.9	5,504,341.6
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	115,513.0	1,220,67.2
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	0.0	0.0
Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	535,307.1	1,050,840.0
Хөрөнгийн зардал	535,307.1	1,050,840.0
Дотоод эх үүсвэрээр	535,307.1	1,050,840.0
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-535,307.1	-1,050,840.0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-419,794.0	169,227.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	497,655.8	77,861.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,861.7	247,088.9

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,888,130.2		17,888,130.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	65,906.0		65,906.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,954,036.2		17,954,036.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0		0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-644,098.0		-644,098.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0		0.0
Тайлант үеийн үр дүн	-1,142,022.7		-1,142,022.7
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-16,167,915.6		16,167,915.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	29,672.7		29,672.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,197,588.3		16,197,588.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-29,672.7		-29,672.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0		0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0		0.0
Тайлант үеийн үр дүн	1,333,157.6		1,333,157.6
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,501,073.3		17,501,073.3

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,556,932.57	(1,556,932.57)	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	15,753,940,300.00	15,656,583,218.43	40,481,381.57	99.7
Урсгал зардал	15,753,940,300.00	15,656,583,218.43	40,481,381.57	99.7
Бараа, ажил үйлчилгээний зардал	15,334,881,300.00	15,334,074,101.43	42,931,198.57	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,371,812,600.00	10,340,716,531.84	31,096,068.16	99.7
Үндсэн цалин	7,108,675,000.00	7,163,184,695.30	(54,509,695.30)	100.8
Нэмэгдэл	2,600,082,600.00	2,515,689,873.00	84,392,727.00	96.8
Унаа хоолны хөнгөлөлт	372,306,000.00	364,268,030.00	8,037,970.00	97.8
Урамшуулал	13,694,700.00	-	13,694,700.00	-
Гэрээт ажлын хөлс	277,054,300.00	297,573,933.54	(20,519,633.54)	107.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,297,000,900.00	1,292,559,497.39	4,441,402.61	99.7
Тэтгэврийн даатгал	933,328,900.00	967,727,089.39	(34,398,189.39)	103.7
Тэтгэмжийн даатгал	90,285,400.00	80,735,165.92	9,550,234.08	89.4
ҮОМШӨ-ний даатгал	73,367,800.00	64,041,509.65	9,326,290.35	87.3
Ажилгүйдлийн даатгал	18,182,200.00	16,537,350.39	1,644,849.61	91.0
Эрүүл мэндийн даатгал	181,836,600.00	163,518,382.04	18,318,217.96	89.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	689,820,400.00	635,714,906.01	54,104,893.99	92.2
Гэрэл, цахилгаан	49,999,100.00	41,435,786.33	8,563,313.67	82.9
Түлш, халаалт	313,714,900.00	277,454,606.61	36,259,693.39	88.4
Цэвэр, бохир ус	48,297,900.00	26,593,648.07	21,704,251.93	55.1
Байрны түрээс	277,808,500.00	290,230,865.00	(12,422,365.00)	104.5
Хангамж, бараа материалын зардал	367,277,600.00	406,678,728.20	(39,401,128.20)	110.7
Бичиг хэрэг	91,903,300.00	95,540,574.00	(3,637,274.00)	104.0
Тээвэр, шатахуун	186,168,100.00	220,030,728.00	(33,862,628.00)	118.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,723,800.00	42,292,601.20	431,198.80	99.0
Ном, хэвлэл	50,000.00	198,200.00	(148,200.00)	396.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	689,000.00	591,200.00	97,800.00	85.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,743,400.00	48,025,425.00	(2,282,025.00)	105.0
Нормативт зардал	7,441,800.00	8,085,190.00	(643,390.00)	108.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,441,800.00	8,085,190.00	(643,390.00)	108.6
Эд хогшил, урсгал засварын зардал	136,440,000.00	156,429,720.00	(19,989,720.00)	114.7
Багаж, техник, хэрэгсэл	11,805,500.00	30,115,645.00	(18,310,145.00)	255.1
Тавилга	-	-	-	
Урсгал засвар	124,634,500.00	126,314,075.00	(1,679,575.00)	101.3
Томилолт, зочны зардал	107,484,100.00	124,960,293.00	(17,476,193.00)	116.3
Дотоод албан томилолт	107,484,100.00	124,960,293.00	(17,476,193.00)	116.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,881,434,100.00	1,849,444,994.69	31,989,105.31	98.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,312,608,500.00	1,281,316,385.69	31,292,114.31	97.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,111,000.00	3,684,100.00	426,900.00	89.6
Даатгалын үйлчилгээ	12,878,600.00	13,534,385.00	(655,785.00)	105.1

Тээврийн хэрэгслийн татвар	3,358,000.00	3,106,124.00	251,876.00	92.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,354,100.00	1,299,400.00	54,700.00	96.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,063,300.00	37,237,320.00	(174,020.00)	100.5
Газрын төлбөр	299,500.00	301,700.00	(2,200.00)	100.7
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	721,700.00	-	721,700.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	509,039,400.00	508,965,580.00	73,820.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	575,169,500.00	519,484,240.30	(1,189,840.30)	100.2
Бараа үйлчилгээний бусад зардал	574,169,500.00	518,484,240.30	(1,189,840.30)	100.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1000,000.00	1000,000.00	-	100.0
Урсгал шилжүүлэг	1,911,100.00	1,644,860.00	266,240.00	86.1
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911,100.00	1,644,860.00	266,240.00	86.1
Бусад урсгал шилжүүлэг	318,148,200.00	317,092,657.00	1,055,543.00	99.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	73,227,900.00	76,358,225.00	(5,130,325.00)	107.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	219,302,700.00	212,128,829.00	7,173,871.00	96.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,617,600.00	28,605,603.00	(988,003.00)	103.6
Хөрөнгийн зардал	-	3,771,600.00	(3,771,600.00)	
Бусад зардал	-	3,771,600.00	(3,771,600.00)	
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	15,753,940,300.00	15,656,583,218.43	152,760,771.57	99.0
Улсын төсвөөс санхүүжих	15,057,986,900.00	14,957,406,684.42	100,580,215.58	99.3
Улсын төсвөөс санхүүжих	3,079,238,300.00	3,077,966,427.04	1,271,872.96	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	11,923,543,900.00	11,879,440,257.38	99,308,342.62	99.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	751,158,100.00	698,865,544.01	52,292,555.99	93.0
Орон нутгийн төсвөөс	751,158,100.00	698,865,544.01	52,292,555.99	93.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	310,990.00	(310,990.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	310,990.00	(310,990.00)	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	61,421,591.00	(61,421,591.00)	
Байгууллагын тоо	23	23	0	
Ажиллагсадын тоо	930	930	0	
Удирдах ажилтан	25	25	0	
Гүйцэтгэх ажилтан	838	838	0	
Үйлчлэх ажилтан	67	67	0	

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,247,052,626.16
УРСГАЛ ЗАРДАЛ		5,247,052,626.16
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,929,162,312.76
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		383,216,926.18
Үндсэн цалин		92,321,760.18
Урамшуулал		88,000.00
Гэрээт ажлын цалин		290,807,166.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		13,650,455.72
Тэтгэврийн даатгал		13,354,608.72
Эрүүл мэндийн даатгал		295,847.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,025,500.00
Түлш, халаалт		2,065,500.00
Байрны түрээс		6,960,000.00
Хангамж, бараа материалын зардал		164,034,293.66
Бичиг хэрэг		57,127,318.66
Тээвэр, шатахуун		95,002,224.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		450,000.00
Ном, хэвлэл		538,450.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,916,301.00
Нормативт зардал		30,606,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		30,606,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		492,923,104.00
Багаж, техник, хэрэгсэл		282,138,980.00
Тавилга		66,192,377.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		6,911,500.00
Урсгал засвар		137,680,247.00
Томилолт, зочны зардал		143,028,932.00
Дотоод албан томилолт		140,728,932.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		2,300,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,552,146,851.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,480,007,891.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		324,000.00
Даатгалын үйлчилгээ		184,500.00
Тээврийн хэрэгслийн татвар		11,968.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо		75,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		6,429,092.00
Газрын төлбөр		276,400.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		64,838,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		1,140,530,250.20
Бараа үйлчилгээний бусад зардал		1,038,400,285.20
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		102,129,965.00
УРСГАЛ ШИЛЖИЛЭГ		1,012,062,807.40
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		39,546,298.10
Засгийн газрын нөөц хөрөнгө		-
Төвлөрүүлэх шилжүүлэг		33,210,643.40
Хөрөнгийн		6,335,654.70
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		668,302,595.85
Төвлөрүүлэх шилжүүлэг		553,855,427.45
Хөрөнгийн		114,447,168.40
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		304,213,913.45
Төвлөрүүлэх шилжүүлэг		304,213,913.45
Бусад урсгал шилжүүлэг		40,437,506.00

Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		11,257,787.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		5,522,920.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		159,889.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал		23,496,910.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		265,390,000.00
Их засвар		-
Тоног төхөөрөмж		76,090,000.00
Бусад хөрөнгө		189,300,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		5,356,415,178.69
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		127,120,287.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагч		262,734,604.29
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид		1,379,752,060.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,582,337,461.80
Төсвийн урамшуулал		4,470,765.60
Мөнгө, тийнтэй адилтгах хөрөнгийн эхний ілдэгдэл		76,304,772.23
Мөнгө, тийнтэй адилтгах хөрөнгийн эцсийн ілдэгдэл		185,667,324.76

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.25			САГ-2020/9/СТА-ТТ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэхээр 258.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 108.2 сая төгрөгийг зарцуулахдаа тайлант үеийн орлого зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	108.2	Зөвлөмж	ГЗБГЗЗГ-ын Дарга СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч	Ц.Ганхүү Л.Лувсан
2	ГЗБГЗЗГ нь өөрийн харьяа 21 аймаг, нийслэлийн санхүүгийн тайланг нэгтгэж Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж тайлагнадаг боловч Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймаг орон нутгийн газрын харилцаа, хот байгуулалтын газрын санхүүгийн тайланг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаар нэгтгэж ГЗБГЗЗГ-ын нэгтгэсэн тайланд устгах бичилтийг хийж	-	Зөвлөмж	ГЗБГЗЗГ-ын Дарга СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч	Ц.Ганхүү Л.Лувсан
3	ГЗБГЗЗГ-ын харьяа аймаг, нийслэлийн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,305.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,130.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 8.3 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 1,003.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлага өгч, 162.8 сая төгрөгийн 30 зөвлөмж өгсөн байна	-	Зөвлөмж	ГЗБГЗЗГ-ын Дарга СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч	Ц.Ганхүү Л.Лувсан

